**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС**
**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН**
**2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2023 оны 12 сарын 06 өдөр — Дархан-Уул аймаг

| **Шийдвэр д/д** | **Заалт д/д** | **Шийдвэрийн нэр, огноо, дугаар** | **Холбогдох заалтын агуулга** | **Хэрэгжилтийн явц** | **Өөрийн үнэлгээ** | **Дээд байгууллагын үнэлгээ** | **Үнэлгээний тайлбар** |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **Монгол Улсын хууль** | | | |
| 1 | 1 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017.12.07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Стандарт, хэмжил зүйн газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд хэлтсийн нийгмийн баталгаа хангах, сургалтын 2023 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт 100%-ийн биелэлттэй дүгнэгдсэн.<br>Хэлтсийн “Төрийн албаны шинэтгэл”-ийн тайланг гаргаж Дархан-Уул аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд албан бичгээр хагас болон бүтэн жилээр тайланг гаргаж хүргүүлсэн. | 100 | | |
| 2 | 2 | Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай 2019—05-30 Дугаар 2019.05.30 | 10.2.2 Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, | “Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран ажиллах "Санамж бичиг"-ийн хүрээнд Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн 17 ерөнхий боловсролын сургуулиудын бага, дунд, ахлах ангийн **20 мянга гаруй** сурагчдад стандартын тухай мэдлэг мэдээлэл өгөх сургалтыг 2023.05.24-26-ны өдрүүдийн хооронд зохион | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу боловсруулж батлуулах | байгууллаа. Тус сургалтаар 3-5 дугаар ангийн сурагчдад "Хүнсний бүтээгдэхүүний шошгыг хэрхэн унших вэ?", 6-9 дүгээр ангийн сурагчдад "Стандартын тухай ерөнхий ойлголт", "Хүнсний бүтээгдэхүүний шошгыг хэрхэн унших вэ?" сургалтыг "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлээр дамжуулан сургалт, мэдээлэл өглөө.<br>Мөн Ерөнхий боловсролын Од цогцолбор сургуулийн 7, 8-р ангийн 90 гаруй сурагчдад "Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодол, шошгыг хэрхэн унших, хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авахад анхаарах зүйлс" сэдвээр сургалт, мэдээлэл өглөө. | | | |
| 3 | 3 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар: 2022.05.01 | 8.2.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн | Байгууллагын эрхэм зорилго, баримтлах зарчим, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, алсын хараа, итгэмжлэлийн болон чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээ, тэргүүлэх чиглэлийг байгууллагын самбараар ил тод байршуулсны зэрэгцээ үйл ажиллагааны стратегийн зорилтыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.<br>Байгууллагаа сурталчилах ажлын хүрээнд masm.gov.mn/da/ сайтад 115, Дархан Стандарт Хэмжилзүйн Хэлтэс facebook, page хуудаст 145 мэдээ бэлтгэж байршуулсан. СХЗГазар болон бусад газрын бэлтгэсэн 500 гаруй мэдээг (share) хуваалцсан, мөн шинээр батлагдсан стандартуудын жагсаалт 4, стандартын мэдээлэл зурагтай бичиг хэлбэрээр 40, стандартын төсөл 100, видео | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 4 | | | хэлбэрээр 30 стандартын мэдээлэл хуваалцсан. Нийт давхардсан тоогоор 934 мэдээ, мэдээлэл нийтлэн сурталчилсныг **20000 гаруй** иргэд үзэж сонирхон 1500 гаруй иргэдийн хандалт авсан байна. | | | |
| | 4 | | 8.2.2. Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг | Баталгаажуулалтын алба, хэмжил зүйн нэгдсэн лаборатори, сорьц тогтоох лаборатори, захиргаа аж ахуй, сургалт мэдээлэл, салбар сан гэсэн бүтэц дээр Засгийн газрын 417 дугаар тогтоолын хүрээнд Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаж тус хэлтсийн харьяанд итгэмжлэгдсэн сорилтын лаборатори, хэмжилзүйн хяналтын улсын байцаагчийн чиг үүрэг нэмэгдэж Стандарт хэмжилзүйн газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/36 тоот тушаалаар нийт 24 орон тоотойгоор батлагдсанаас 1 албан хаагч хүүхэд асрах чөлөөтэй, 23 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна.<br>Хаяг: Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс Дархан-Уул аймаг Дархан сум 6-р баг, өөрийн байр утасны дугаар: 70377194, 1800-2525<br>Байгууллагаа сурталчилах ажлын хүрээнд masm.gov.mn/da/ сайтад 115, Дархан Стандарт Хэмжилзүйн Хэлтэс facebook, page хуудаст 145 мэдээ бэлтгэж байршуулсан. СХЗГазар болон бусад газрын бэлтгэсэн 500 гаруй мэдээг (share) хуваалцсан, мөн шинээр батлагдсан стандартуудын жагсаалт 4, стандартын мэдээлэл зурагтай бичиг | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэлбэрээр 40, стандартын төсөл 100, видео хэлбэрээр 30 стандартын мэдээлэл хуваалцсан. Нийт давхардсан тоогоор 934 мэдээ, мэдээлэл нийтлэн сурталчилсныг **20000 гаруй** иргэд үзэж сонирхон 1500 гаруй иргэдийн хандалт авсан байна.Тус хэлтсээс үзүүлдэг үйлчилгээний талаарх мэдээллийн 6 самбаруудыг 1 давхрын үйлчилгээний хэсэгт байршуулсан. | | | |
| | 5 | | 8.2.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж | Дархан–Уул аймаг дахь Төрийн аудитын газраас тус хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийж 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 30 тоот албан бичгээр “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.<br>Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг хэлтсийн “Төсөв санхүүгийн ил тод байдал” самбараар болон www.masm.gov.mn цахим хуудсанд байршуулсан. | 100 | | |
| | 6 | | 8.2.4. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт-95.7%, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт-100%, Шадар сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт-100%, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт-100%, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт-100%, хяналт- | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 7 | | | шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийн мөрөөр боловсруулж баталсан ”Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”-ний хэрэгжилт-100%, хэлтсийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилт-100%-тай байна. | | | |
| | 7 | | 8.2.5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан | Аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг веб хуудсанд байршуулсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгаж, улмаар хэмжилзүйн улсын байцаагч, итгэмжлэгдсэн сорилтын лабораторийг Стандарт, хэмжил зүйн газрын харьяанд шилжүүлэх шийдвэрийн дагуу аймгийн хэмжил зүйн улсын байцаагч, итгэмжлэгдсэн сорилтын лабораторийн албан хаагчдын ашиглаж байгаа үндсэн хөрөнгө, бараа материал, компьютер, техник хэрэгслийг хэлтсийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн баталсан А/01 дүгээр тушаалаар томилогдсон “Ажил хүлээлцэх тооллогын комисс” нь данс бүртгэлийн дагуу хүлээн авах, шилжин ирж байгаа үндсэн хөрөнгийг нэг бүрчлэн нүд үзэж тоолж ажил хүлээлцэв.<br>Туст хэлтсийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 1.001.3 сая төгрөгийн өртөг бүхий 112 нэр төрлийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тооллогын программд шивж оруулсан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний тушаалаар томилогдсон ажлын хэсэг батлагдсан хуваарийн дагуу 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Дархан Уул аймагт ажиллаж, тус хэлтэс 2022 оны “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г 93%-тай дүгнүүлсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 657 дугаар тогтоолын биелэлтийг хэлтсийн даргын 2023 оны 02 дугаар сарын 16-ны 64 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 28-ны “Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 120 дугаар тогтоолоор Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газар (хуучин нэрээр)-ын хөрөнгөнд бүртгэлтэй нийт 116 нэрийн 266,711,878.09 (Хоёр зуун жаран зургаан сая долоон зуун арван нэгэн мянга найман зуун далан найм есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 246,926,701.94 (Хоёр зуун дөчин зургаан сая есөн зуун хорин зургаан мянга долоон зуун нэг мянга ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтын дагуу шилжүүлэн авч үнийг шинэчлэн тогтоож үндсэн хөрөнгөд бүртгэн авч хэрэгжилтийг хэлтсийн даргын 2023 оны 06 дугээр сарын 30-ны 140 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тухай“ тогтоолоор Мэргэжлийн хяналтын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй (Дархан Уул аймгийн Дархан сум, 12 дугаар баг, Хүрээлэн12, 1265 тоот) байршилд байгаа 2250 мкв газрын эзэмшигчийн нэрийг сольж, гэрээг шинэчлэх хүсэлтийг Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хэлтсийн даргын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 119 тоот албан бичгээр хүргүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулан данс бүртгэлд бүртгэсэн. | | | |
| | 8 | | 8.2.6. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт | Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актын 76 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд хэрэгжилтийг веб-д байршуулсан. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”, “Хэмжил зүйн тухай хууль”, “Эрдэнэсийн сангийн хууль”, Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, “Ашигт малтмалын тухай хууль”, Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай Улсын их хурлын байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоолууд, холбогдох дүрэм журам, стандарт, зааврудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15.2.5, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15.2.3, Хүнсний бүтээгдэхүүний | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 9 | | | аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15.2.6, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15.2.6 дугаар заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | | | |
| | 9 | | 8.2.7. Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг/эх/ -ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудан хаяг | Байгууллагын ажилтнуудын холбогдох мэдээллийг цахимд болон мэдээллийн самбараар ил байрлуулсан.<br>Төрийн захиргааны албан хаагчид нь Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн №А/89 дугаар тушаалаар баталж, Төрийн албаны зөвлөлөөр хянуулсан албан тушаалын тодорхойлолтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Мөн албаны цахим шуудангийн хаягийг Стандарт, хэмжил зүйн газрын мэдээлэл хариуцсан ажилтанд албан бичиг явуулж хүсэлт өгсний дагуу албан хаагчид албаны masm.gov.mn хаягтай болсон. Энэхүү мэдээллийг www.masm.gov.mn болон орон нутгийн төрийн байгууллагын www.masm.gov.mn/da/ цахим хуудас, байгууллагын 1 давхрын мэдээллийн самбарт төрийн үйлчилгээг үзүүлж байгаа албан хаагчдын мэдээлэл, харилцах утасны дугаар, үзүүлж буй үйлчилгээний нэр төрөл зэргийг байршуулж, мэдээлсэн. | 100 | | |
| | 10 | | 8.2.8. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ | Аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.<br>Нийт – 1610<br>1. Төрөлжсөн үйлчилгээнд хамрагдах | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүсэлт- 1570<br>2. Албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл- 37<br>3. Гомдол- 1<br>4. Санал-3<br>/-стандартчилал 72<br>-тохирлын баталгаажуулалт 205<br>-хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 43<br>-сорьц тогтоох лабораатори -632<br>-сорилтын лаборатори -618/<br>1 ажилтан цалинтай чөлөө олгох, 6 албан хаагчийг шилжүүлэн томилох тухай, 2 албан хаагч хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусч ажилд томилох тухай, 1 албан хаагч шилжүүлэн томилох тухай, 1 албан хаагч сэлгэн ажилуулах тухай, 6 албан хаагчид буцалтгүй тэтгэмж олгох тухай, 5 иргэн ажилд орох хүсэлт гаргасаныг даргын зөвлөл хэлэлцэн, хөдөлмөрийн түр гэрээ байгуулан ажиллуулсан бөгөөд өөрсдийн хүсэлтээр чөлөөлөгдөх өргөдөл 2 ажилтан өгч, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт ирүүлснийг хэлтсийн дарга өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэсэн.<br>Үр дүн: 2023 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг тус хэлтсийн удирдлага, үнэт металлын сорьц тогтоох лаборатори, сорилтын лаборатори, бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтэн, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтнүүд хуулийн хугацаанд өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэн ажилласан.<br>Тус хэлтсийн үйл ажиллагаа болон | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажилтнуудын ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол ирээгүй. | | | |
| | 11 | | 8.2.9. Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл | Хэмжих хэрэгсэл болон бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын мэдээллийг улирал бүр шинэчлэн веб-д байршуулж хэвшсэн.<br>Хэмжил зүйн статистик мэдээг сар бүр, хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээг улиралд нэг удаа маягтын дагуу гаргаж dambaa@masm.gov.mn, lutaa@yahoo.com, dashdulam@masm.gov.mn, enhe2345@gmail цахим хаягуудад илгээж байна.<br>Тохирлын гэрчилгээ эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг агуулсан мэдээллийг www.masm.gov.mn цахим хуудсанд байрших “Баталгаажуулалтын мэдээллийн нэгдсэн сан”-д тухай бүр бүртгэн ажиллаж байна.<br>Лабораторийн нэгдсэн сүлжээ LIMS програм буюу gasi.shinjilgee.mn системд 370 аж ахуйн нэгж байгууллага, 248 иргэний хүсэлтээр 3523 сорьцод 8147 үзүүлэлтээр шинжилгээ шинжилгээ хийж, мэдээллийг 100% бүртгэж оруулсан бөгөөд мэдээллийг хоцроосон тохиолдол гараагүй болно. | 100 | | |
| | 12 | | 8.2.10. Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний | Байгууллагаас зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг фэйсбүүк хуудас болон веб хуудсанд тухай бүр нь байршуулж хэвшүүлсэн.<br>Хэлтсээс зохион байгуулж байгаа олон | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөтөлбөр | нийтийн арга хэмжээний хөтөлбөрийг цахим болон цаасан хэлбэрээр төр болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд зарлан мэдээлж ажиллаж байна. Тухайлбал:<br>-4 суманд зохион байгуулсан “Стандарт таны амьдралын баталгаа” сэдэвт “Нээлттэй хаалганы өдөрлөг”,<br>-"Стандарт ба хөгжил" үндэсний хөтөлбөрийн төсөлд санал авах нээлттэй хэлэлцүүлэг,<br>-MNS ISO 9001:2016 "Чанарын менежментийн тогтолцоо, шаардлага" стандартын сургалт, Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран ажиллах "Санамж бичиг"-ийн хүрээнд<br>-Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн 17 ерөнхий боловсролын сургуулиудын бага, дунд, ахлах ангийн **20 мянга гаруй** сурагчдад стандартын тухай мэдлэг мэдээлэл өгөх сургалт,<br>-“ДСЦТС” ХК-ийн 65 борлуулалт, тоолуур, хэмжих хэрэгсэл хариуцсан ажилтнууд, сумдын техникч нарт “Хэмжил зүйн тухай хууль”, “Хэмжих хэрэгсэл шалгалт баталгаажуулалтад хамруулах журам” болон холбогдох журмуудаар танхим болон цахимаар хосолсон сургалт,<br>-Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийн хүрээнд Од цогцолбор сургуулийн 7, 8-р ангийн 90 орчим сурагчдад | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулсан сургалт,<br>-Үсчин гоо сайханчдад зориулсан сургалт<br>-Стандарт хэмжилзүйн салбарын 100 жилийн ой, урлаг спортын наадам,<br>-Үзэсгэлэн худалдаа,<br>-Чанарын 7 хоног<br>-Эрсдэл ба стандарт үндэсний форум гэх мэт сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу олон нийт рүү чиглэсэн 12 удаагийн арга хэмжээний хүрээнд 1055 иргэд, аж ахуй нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн 3-12 ангийн **20 мянга гаруй** сурагчдад стандарт, хэмжилзүйн ойлголт өгөх сургалт мэдээлэл, хэлэлцүүлэг, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулан ажиллаж 1000 гаруй гарын авлага, тараах материалаар ханган ажилласан. | | | |
| | 13 | | 8.3.1. Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл | Хэлтэс нь 24 орон тоотой үйл ажиллагаа явуулахаас 1 албан хаагч хүүхэд асрах чөлөөтэй, цалингийн сандаа багтаан жолооч орон тоон дээр ажилтан авалгүйгээр 23 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд одоогоор төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тооны захиалга байхгүй болно. | 100 | | |
| | 14 | | 8.3.2. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам | Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулалт болон Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн тогтоол, шийдвэр, журмыг мөрдөн ажиллаж байна. | 100 | | |
| | 15 | | 8.3.3.Албан хаагч, | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажилтны ёс зүйн дүрэм | https://www.facebook.com/darkhan.standart цахим хуудсанд байршуулсан. Албан хаагчид нь төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, журмыг баримтлан ажиллаж байна. | | | |
| | 16 | | 8.3.4.Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам | Хүний нөөцийн стратегийн хувьд ёс зүйн зөвлөл, дотоод журам, нийгмийн баталгаа хангах төлөвлөгөө, төрийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө, ХШҮ-ний журмуудын хүрээнд үйл ажиллагааг төлөвлөн ажилладаг. | 100 | | |
| | 17 | | 8.3.5.Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ | Хэлтсийн 2023 оны орон тоо, цалингийн санг Стандарт, хэмжил зүйн газрын даргын А/36 дугаар тушаалаар 24 орон тоотой үйл ажиллагаагаа явуулахаас цалингийн сандаа багтаан жолооч, лаборантын орон тоон дээр ажилтан авалгүйгээр 23 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Итгэмжлэгдсэн сорилтын лабораторийн лаборант, үнэт металлын сорьц тогтоох лабораторийн үнэт металл хайлагч орон тоон дээр ажилтан авах зарыг 2 удаа хэлтсийн цахим хаягт байршуулсан бөгөөд холбогдох мэргэжлийн шаардлага хангасан 2 иргэнийг ажилд авсан. | 100 | | |
| | 18 | | 8.3.6.Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг веб хуудсанд байршуулсан бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар 22 албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхээр хуулийн хугацаанд тайлангуудыг авсан. МУЗГ-ын 2023 оны 08 дугаар сарын 23-ны 301 дугаар тогтоол “Төрийн жинхэнэ албан | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын танилцуулыг Дархан-Уул аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичигийн дарга А.Лхагважаргал нийт албан хаагчдад мэдээлэл өгсөн. | | | |
| | 19 | | 8.4.1.Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл | 2022 оны байдлаар 406,6 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд төсвийг зориулалт тус бүрээр зарцуулж ажилласан.<br>2023 оны жилийн эцсийн байдлаар 622.8 сая төгрөгийн төсөв батлагдсан.<br>Батлагдсан 627,6 сая төгрөгийг улсын төсвөөс 159,8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 461.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 5.9 сая мянган төгрөг урсгал зардлын санхүүжилт хийгдэхээр төлөвлөгдсөн байна.<br>Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны №01/286 тоот 2024 оны төсвийн төсөл 2025-2026 оны төсвийн төсөөллийг ирүүлэх тухай албан бичгийн дагуу төсөв, төсөөллийг “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2015 оны тушаалыг үндэслэн хийж батлуулан тайлбар тодруулгын хамт Стандарт, хэмжилзүйн газарт 2023 оны 04 дүгээр сарын 21-ний 93 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 | | |
| | 20 | | 8.4.2.Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас бүтэн жилийн | 2023 оны жилийн эцсийн байдлаар 627.6 сая төгрөгийн төсөв батлагдсан.<br>Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажилласан. Жилийн эцсийн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | санхүүгийн тайлан | санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн тохируулсан аккруэл сууриар нягтлан бодох бүртгэл хөтөлж тайлагнасан. | | | |
| | 21 | | 8.4.3.Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт | Дархан–Уул аймаг дахь Төрийн аудитын газраас тус хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийж 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 30 тоот албан бичгээр “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.<br>Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг хэлтсийн “Төсөв санхүүгийн ил тод байдал” самбараар болон www.masm.gov.mn цахим хуудсанд байршуулсан. | 100 | | |
| | 22 | | 8.4.4.Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ | Хэмжил зүйн нэгдсэн лаборатори нь Шадар сайдын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 117 тоот тушаалаар баталсан “Хэмжил зүйн ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай”, баталгаажуулалтын алба нь 2019 оны 03 дугаар сарын 27-ны 22 дугаар тушаалаар баталсан “Баталгаажуулалтын ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг батлах тухай”, үнэт металлын сорьц тогтоох лаборатори нь 2020 оны 01 дүгээр сарын 23-ны 08 тоот “Үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн батлах тухай” тушаал, итгэмжлэгдсэн сорилтын нэгдсэн лаборатори нь Сангийн сайдын 253 дугаар тушаалаар баталсан төлбөр, хураамж, үйлчилгээний хөлсний хэмжээг үйл ажиллагаандаа мөрдлөг | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | болгон ажиллаж байна. | | | |
| | 23 | | 8.4.5.Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | 2023 оны жилийн эцсийн байдлаар 627.6 сая төгрөгийн төсөв батлагдсан ба батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан. | 100 | | |
| | 24 | | 8.4.6.Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг | Биечилсэн хамгаалалтын төлбөр 5,1 сая төгрөг “Дархан секьюрити” ХХК Дархан-Уул аймаг, Дархан сум 10-р баг Поликомын байранд, Хүүхдийн өрөөний засварын төлбөр 7,4 сая төгрөг “Рийж ган” ХХК, Дархан-Уул, Дархан сум, 14 дугаар баг ,2-р хороолол 49-616 тоот.<br>Хэлтсийн 2 давхрын урсгал засварын төлбөр 19,6 сая төгрөг “Төмөр замын залуус” ХХК, Дархан-Уул Дархан сум 6-р баг “Их цагаан туг” ХХК-ийн байранд иргэн Д.Дахинбаярт суурин болон зөөврийн компьютерын төлбөр 9,9 сая төгрөг<br>Дархан-Уул аймаг, Дархан сум 10-р баг 12 хороолол бичил хотхон 9-1 тоотод оршин суух ахмад ажилтан Д.Мадагбавууд олгосон нэг удаагийн буцалтгүй тусламжийн 6,0 сая төгрөг,<br>Дархан-Уул аймгийн Дархан сум 11-р баг 6-р хороолол 20-р байр 9 тоот “Кемикал менежмент” ХХК-иас худалдан авсан сэлбэгний үнэ болох 6,0 сая төгрөг УБ хот Баянгол дүүрэг 4-р хороо Энхтайваны өргөн чөлөө 92 UB Platinum байрны 604 тоот. | 100 | | |
| | 25 | | 8.4.7.Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс | Улсын төсвийн урсгал санхүүжилтийн 96,9 сая төгрөгийн 6 орлогын гүйлгээ, нэмэлт санхүүжилтийн дансанд давсан орлого болон | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт | дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө нийт 73,0 сая төгрөгийн 2 орлогын гүйлгээ, үндсэн үйл ажиллагааны орлогын 78,9 сая төгрөгийн 6 гүйлгээ нийт 14 орлогын гүйлгээг www.shilendans.gov.mn сайтад шивсэн.<br>“Дархан секьюрити” ХХК-д биечилсэн хамгаалалтын төлбөр 5,1 сая, “Рийж ган” ХХК-д хүүхдийн өрөөний засварын төлбөр 7,4 сая төгрөг, “Төмөр замын залуус” ХХК-д хэлтсийн 2 давхрын урсгал засварын төлбөр 19,6 сая төгрөг,<br>Иргэн Д.Дахинбаярт суурин болон зөөврийн компьютерын үнэ 9,9 сая төгрөг,<br>Д.Мадагбавууд олгосон нэг удаагийн буцалтгүй тусламжийн 6,0 сая төгрөг,<br>Кемикал менежмент ХХК-наас худалдан авсан сэлбэгний үнэ болох 6,0 сая төгрөг 6 зарлагын гүйлгээг шивж байршуулсан. | | | |
| | 26 | | 8.4.8.Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр | 2023 оны жилийн эцсийн байдлаар төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой СХЗХ-ийн даргын 77 тушаал, түрээсийн гэрээний сунгалт, төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авалттай холбоотой 2 холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 10-р хавсралтын дагуу www.shilendans.gov.mn сайтад шивж байршуулсан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 27 | | 8.4.9.Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл | Жилийн эцсийн байдлаар төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой хэлтсийн даргын 77 тушаал, 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, сар улирлын гүйцэтгэл зэргийг www.shilendans.gov.mn 175 удаа шивж байршуулсан. | 100 | | |
| | 28 | | 8.4.10.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн бичиг баримт, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч | Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний А/222 дугаар тушаалаар тус хэлтэст хуваарилсан давсан орлогоос 9,9 сая төгрөгөөр суурин болон зөөврийн компьютер худалдан авсан.<br>Тайлант хугацааны урсгал санхүүжилтаар Үнэт металлын сорьц тогтоох лабораторид 2,8 сая төгрөгөөр хүчдэл тогтворжуулагч, 1,1 сая төгрөгөөр электрон жин худалдан авсан. Мөн 3,3 сая төгрөгөөр 2 ширхэг принтер 1 ширхэг хурдан сканер худалдан авсан байна.<br>Дархан-Уул аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны “Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалт баталж эрх шилжүүлэх тухай” 01/А-151 тоот захирамжаар олгосон 15,0 сая төгрөгөөр “Цахим сургалтын танхим” тохижуулсан.<br>15 сая төгрөгөөр 1 давхарын урсгал засвар хийсэн. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан | | | | |
| | 29 | | 8.4.11.Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт | Хамааралгүй | - | | |
| | 30 | | 8.4.12.Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл | Хамааралгүй | - | | |
| | 31 | | 8.4.26.Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, | Төсвийн тодотголоор хэлтсийн хүүхдийн өрөөний урсгал засварын 7,4 сая төгрөгийн санхүүжилтыг шийдвэрлүүлж 2022 онд үүсээд байсан өр төлбөрийг 100% барагдуулсан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилт, явц, үр дүн | | | | |
| | 32 | | 8.4.27.Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан | Хэлтсийн 2 давхрын урсгал засварын ажлыг хийлгэхээр “Төмөр замын залуус” ХХК-тай 2022 оны 12 дугаар сард “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулсан бөгөөд гэрээнд заасан хугацаанд 2-р давхрын засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Хүүхдийн өрөөний засварын ажлыг ”Рийж ган” ХХК-тай 7,4 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэхээр 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдөр 01 тоот гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг 100% олгосон. | 100 | | |
| | 33 | | 8.4.28.Хууль тогтоомжид заасан бусад | 19 ААН, иргэний 16 нэр төрлийн 147 бүтээгдэхүүн, 221 ААН, иргэний 9 нэр төрлийн 228 нэрийн үйлчилгээний газарт баталгаажуулалт хийж, дотоодын 242 ширхэг, экспортын 592 ширхэг гэрчилгээ, үнэт мелаллын сорьц тогтоох лаборатори нь алт олборлогч 13 аж ахуйн нэгж, 17 иргэнд давхардсан тоогоор 632 удаагийн үйлчилгээ үзүүлж, 774 ширхэг алтан гулдмай буюу нийт 1974,7 кг үнэт металлын хайлш хайлснаас 1960,1 кг үнэт металлд MNS/ISO/11426:2017 стандартын дагуу сорьц тогтоох шинжилгээ хийн сорьцын баталгаа олгосон.<br>Лабораторийн нэгдсэн сүлжээ LIMS программ буюу gasi.shinjilgee.mn системд 370 ААНБ, 248 иргэний хүсэлтээр 3523 сорьцын 8147 үзүүлэлтээр шинжилгээ хийж, мэдээллийг 100% бүртгэж оруулсан.<br>Хэмжил зүйн лаборатори нийт 12386 | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ширхэг хэмжүүр, хэмжих хэрэгсэл баталгаажуулсан.<br>80 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 60 төрлийн 72 стандартыг борлуулж 500 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч үйлчилгээ үзүүлсэн. | | | |
| | 34 | | 8.5.1.Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл | Тохирлын үнэлгээнд шинээр болон дахин хамрагдахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэл, үнийн мэдээллийг веб хуудсанд байршуулсан.<br>Тус хэлтсээс үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, үнэт металлын сорьц тогтоох үйлчилгээний төлбөрийн мэдээлэл, бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтад хамруулахад бүрдүүлэх материалын жагсаалтыг байгууллагын www.masm.gov.mn/da/ цахим хуудасны холбогдох цэсүүдэд болон 1-р давхарт байрлах 5 мэдээллийн самбаруудад ил тод байршуулсан.<br>Стандартын мэдээллийн нэгдсэн сан estandard.gov.mn сайтад Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй 6000 гаруй стандартыг иргэн, аж ахуйн нэгж байгууллага хүссэн стандартаа цахимаар хайх, танилцах, худалдаж авах ажиллагаа бүрэн цахим хэлбэрт шилжлээ.<br>Тус хэлтэс нь Дархан Стандарт хэмжилзүйн Хэлтэс нэртэй фэйсбүүк хаяг, байгууллагын www.masm.gov.mn/da/ цахим хуудсаар дамжуулан холбогдох мэдээ | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээлэл, шинээр батлагдсан стандартуудын талаарх мэдээллүүдийг тогтмол хүргэж байна.<br>Хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай" Монгол улсын Шадар сайдын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 117 дугаар тушаалын дагуу хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын ажлыг, "Стандартын үнэ, ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох тухай" Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2015 оны 03 сарын 13-ны өдрийн А/64 тоот тушаалын дагуу стандарт, мэдээлэл лавлагаа, "Баталгаажуулалтын ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг батлах тухай" Монгол улсын Шадар сайдын 2019 оны 03 сарын 27-ны өдрийн 22 дугаар тушаалын дагуу баталгаажуулалтын ажлыг тус тус гүйцэтгэж байна.<br>Дээрх төлбөрийн хэмжээг хүлээн авдаг үндсэн үйл ажиллагааны данс:100190009001, туслах үйл ажиллагааны данс:100190009401 зэрэг мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр мэдээлж байна. | | | |
| | 35 | | 8.5.2.Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, | Давхардсан тоогоор 221 ААН, иргэний 9 нэр төрлийн 228 үйлчилгээний газарт баталгаажуулалт хийж, тохирлын гэрчилгээг олгосон.<br>13 аж ахуйн нэгж, иргэний 6 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортод гаргахаар хүсэлт гаргасны дагуу тухай бүр тохирлын үнэлгээг хийж 592 ширхэг сертификат олгож, улсын | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа | төсөвт 42,979.700 төгрөгийг төвлөрүүллээ. Үүнд:<br>-Таймлесс ХХК 2235 ширхэг эсгий бүтээгдэхүүнийг Норвеги, Чех улс руу,<br>-Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК, Ган бөмбөлөг ундарга ХХК, Феррум металл монголия ХХК, Хайрхантоб ХХК, Эйч Эс Эм Жи ХХК, Жи ар капитал логистик ХХК, Херо хүдэр ХХК-иуд нийт 982357 тонн төмрийн баяжмал болон төмрийн хүдрийг БНХАУ улс руу,<br>-Дархан меат фүүдс ХХК 86726т махыг Казакстан, Узбекистан, БНХАУ, Иран улс руу,<br>-Дархан минж ХХК 9105 ширхэг ширийг БНХАУ руу,<br>-Нэхий таннери ХХК 119,7 кг А сортын хонины арьсыг Недерланд улс руу,<br>-ХХЭ Н.Мөнгөнбаяр Монгол гэрийг БНХАУ руу,<br>-Алижан ХХК 11,3 тонн адууны дайвар бүтээгдэхүүнийг тус тус экспортод гаргалаа. | | | |
| | 36 | | 8.6.1.Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн | "СТАНДАРТ БА ХӨГЖИЛ" үндэсний хөтөлбөрийн төсөлд санал авах нээлттэй хэлэлцүүлгийг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр АШУҮИС Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны сургуулийн хурлын танхимд зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Стандарт Хэмжилзүйн газрын Хяналт шинжилгээ, дотоод аудитын газрын дарга С.Батбаатар, Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын дарга Д.Даваасүрэн, СХЗГ-ын Захиргаа удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Б.Эрхүү, аймгийн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | санал | Засаг даргын орлогч Б.Жавхлан, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга П.Батсүх, хэлтсийн дарга Б.Цэвээндорж, хэлтсийн нийт албан хаагчид болон орон нутгийн эрчим хүч, дэд бүтэц, газрын тос, уул уурхай, хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбар, их дээд сургуулийн төлөөллүүд зэрэг 153 байгууллагын 184 иргэний оролцоотойгоор зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт оролцогчид хөтөлбөртэй холбоотой болон цаашид өөрчлөлт, шинэчлэлт оруулах шаардлагатай стандартын талаарх санаа бодлоо илэрхийллээ. Иргэдээс гарсан саналыг авч нэгтгэн Стандарт хэмжилзүйн газар хүргүүлсэн.<br>Монгол улсын стандартын мэдээллийн нэгдсэн сан www.estandard.gov.mn сайтад байршуулсан 50 стандартын төслүүдийн санал авах тухай линкийг хэлтсийн Дархан Стандарт Хэмжилзүйн Хэлтэс фэйсбүүк хуудсанд байршуулж, мэдээллийг түгээлээ. Иргэд олон нийтээс манай хэлтэст санал ирүүлээгүй болно.<br>"ДЭЛХИЙН ЧАНАРЫН ӨДӨР"-ийг тохиолдуулан Дархан-Уул аймгийн СХЗХэлтэс, ШУТИС Да ТИС-ийн Инженерчлэлийн салбар хамтран "БҮТЭЭМЖ БА ИННОВАЦИ -2023" Олон улсын эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал зохион байгуулав. Тус хуралд 100 гаруй багш, судлаач, оюутан, албан хаагчид танхим болон | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | цахим хэлбэрээр /нийслэл, 21 аймгаас/ хамрагдаж 31 гаруй эрдэм шинжилгээний ажил, илтгэл тавьсан.<br>Монгол Улсын Шадар сайдын ивээл дор Монгол Улсын нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжилд нөлөөлөх уур амьсгалын өөрчлөлт, байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг тодорхойлох, учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах, стандартыг сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх зорилго бүхий “Эрсдэлийн Үндэсний Форум” улсын хэмжээнд нийслэл болон 21 аймагт нэгэн зэрэг зохион байгуулагдсан ба манай аймагт ЗДТГ-ын хурлын танхимд нээлттэйгээр төр, аж ахуйн нэгж, жижиг дунд үйлдвэр эрхлэгч, хэвлэл мэдээллийн зэрэг салбарын 110 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулагдсан. | | | |
| | 37 | | 8.6.2.Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт | Стандарт хэмжил зүйн хэлтэст байхгүй бөгөөд Стандарт хэмжилзүйн газрын гэрчлэх тэмдэг авсан байна. | - | | |
| | 38 | | 8.6.3.Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл | Хамааралгүй. | - | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 39 | | 8.6.4.Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл | Дархан-Уул аймгийн Дархан сум 19 дүгээр хороолол Ардын өргөн чөлөөнд “Төрийн захиргааны байгууллага” ашиглах зориулалтаар 4506503258 дугаар бүхий нэгж талбартай, Э-2003001319 дугаар бүхий 2161 м2 газрыг Дархан-Уул аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01-А/195 захирамжийн дагуу эзэмшдэг.<br>Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний 109 дүгээр тогтоолоор Дархан-Уул аймгийн Дархан сум, 12 дугаар баг, Хүрээлэн 12,1265 тоотод байрлах 2150 м2 газрыг эзэмшиж байна. | 100 | | |
| | 40 | | 8.6.5.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг | 2023 оны жилийн эцсийн байдлаар Дархан–Уул аймгийн Татварын хэлтсийн 100190000901 тоот дансанд цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварт 33,1 сая төгрөг төлсөн. | 100 | | |
| | 41 | | 8.6.6.Төрийн болон | Байгууллагын www.masm.gov.mn/da/ | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/ -ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавих шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл | цахим хуудас, байгууллагын 1 давхрын мэдээллийн самбарт төрийн үйлчилгээг үзүүлж байгаа албан хаагчдын мэдээлэл, харилцах утасны дугаар, үзүүлж буй үйлчилгээний нэр төрөл зэргийг байршуулж, мэдээлсэн.<br>Тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баярбаатар СХЗГ-ын даргын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/36 тоот тушаалаар сорьцын хяналтын улсын байцаагч бөгөөд ахлах мэргэжилтнээр томилогдох бүтэц орон тоо баталсан.<br>Авлигатай тэмцэх газраас 2023 оны 05-р сарын 10-ны өдөр ирүүлсэн “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай” 05/8187 тоот албан бичгүүдийг үндэслэн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний Б/32 тоот тушаалаар сорьцын хяналтын улсын байцаагч бөгөөд ахлах мэргэжилтнээр томилогдон ажиллаж байна.<br>Авлигатай тэмцэх газраас 2023 оны 10-р сарын 27-ны өдөр ирүүлсэн “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай” 05/17341 тоот албан бичгүүдийг үндэслэн Үнэт металлын сорьц тогтоох лабораторийн эрхлэгчээр томилогдон ажиллаж байна. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 42 | | 8.6.8.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл | Хэлтсийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь үнэт металл худалдан авах нэг цэгийн үйлчилгээний үнэт металл худалдан авах, үйлчилгээний хөлс төлбөр төлөх зориулалт бүхий 45,5 м2 2 өрөөг Монгол банкнаас зөвшөөрөл олгосон арилжааны банкинд түрээслүүлэх сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу хийж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Капитрон банктай 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 2023/01 тоот гурвалсан гэрээ байгуулсан.<br>Түрээслэгч банк нь түрээсийн төлбөр болох 4,9 сая төгрөгийг тус хэлтсийн 100190009001 тоот дансанд шилжүүлсэн.<br>Дархан Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 01 сарын 18-ны өдрийн 23 тоот албан бичиг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 28-ны “Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 120 дугаар тогтоолоор Дархан Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газар (хуучин нэрээр)-ын хөрөнгөд бүртгэлтэй байсан 37 нэрийн 51 ширхэг 24,5 сая төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжгүй хөдлөх хөрөнгийг актлах саналыг хэлтсийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний 245 тоот албан бичгээр холбогдох газарт хүргүүлсэн. Тайлант хугацаанд хөрөнгө ашиглалтаас гаргах холбогдох шийдвэр гарсан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 43 | | 8.6.10.Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл | Тус хэлтсийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа тоног төхөөрөмжүүд нь олон улсын шаардлага хангасан төхөөрөмжүүд хэрэглэдэг бөгөөд химийн лабораториос гарсан ашигласан капель буюу химийн бодисын хаягдлаа түр хадгалах агуулахад хадгалдаг. Хэлтсийн албан хаагчид гарч байгаа хог хаягдлаа цуглуулж /цаасан, дахивар, зай, принтерийн хор, бусад хог хаягдал гэх мэт/ ангилан, хаяж байна. Байгууллагын албан хаагчид, үйлчлүүлэгчид 3 өнгийн ангилан хаях хогийн саванд хогийг хаяж, гадаа талбайд байршуулсан хуванцар хогийн саванд хийж хэвшсэн.<br>2023 оны 11-р сарын 08-ны өдөр “ЭЛЕМЕНТ” ХХК –тай химийн хорт болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 01–ний өдөр хүчлийн хуванцар сав 5 ширхэг, хаягдал 750 орчим кг хаягдлыг “ЭЛЕМЕНТ” ХХК–д устгуулахаар хүлээлгэн өгсөн. | 100 | | |
| | 44 | | 8.6.11.Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт | Байхгүй. | - | | |
| | 45 | | 8.6.20.Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй | www.masm.gov.mn цахим хуудсанд байрших “Баталгаажуулалтын мэдээллийн нэгдсэн сан”-д тус аймагт баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл | нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоохгүйгээр нээлттэй өгөгдөл болгон ашиглуулахаар байршуулж байна.<br>Стандартын мэдээллийн нэгдсэн сан, стандартын төсөлд санал авах мэдээллийг иргэд хэрэглэгчдэд танилцуулах ажлыг сургалт сурталчилгаа бүрд хийж байна.<br>Хэмжил зүйн мэдээллийн нэгдсэн санд оруулах мэдээллийг сар бүр СХЗГазарт хүргүүлж байна.<br>Тохирлын гэрчилгээ авах хүсэлтийг E-mongolia цахим системд холбосон. | | | |
| | 46 | | 8.6.21.Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/ -ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт | Байгууллагын зардлаар суралцаж буй хүүхэд байхгүй болно. | - | | |
| | 47 | | 8.6.22.Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан | Жилийн эцсийн байдлаар төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой хэлтсийн даргын 77 тушаал, 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт, тухайн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | | бусад мэдээлэл | байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, сар улирлын гүйцэтгэл зэргийг www.shilendans.gov.mn 175 удаа шивж байршуулсан. | | | |
| | **Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | | |
